“БУЯНТ-УХАА” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ БОЛОН НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА ХООРОНДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас Харилцан ажиллагааны зохицуулалтын журмын хамт хүчин төгөлдөр байна.

Байгууллага: “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал
Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба

	Албан тушаал, нэр, гарын үсэг	Огноо
Баталсан	“БУЯНТ-УХАА” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ЗАХИРАЛ Л.ОТГОНЖАРГАЛ НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ДАРГА Г.МӨНГӨЛДЭЙ	2026.10.08
Хянасан	“БУЯНТ-УХАА” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ө.ЖАНЧИВ НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ МЕНЕЖЕР Б.ГАНБААТАР	2026.10.08 2026.10.08
Боловсруулсан	“БУЯНТ-УХАА” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТИЙН ДАРГА Б.ЦЭДЭВДОРЖ	2026.10.08

“Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал болон Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба хоорондын харилцан ажиллагааны зохицуулалтын журам”-д нэмэлт өөрчлөлтийг уг журмыг Хянасан албан тушаалтан хянан баталгаажуулна.

Журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажилтан доорх хүснэгтийг заавал бөглөсөн байх шаардлагатай.

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Хүчинтэй болох огноо	Оруулсан огноо	Нэмэлт өөрчлөлт орсон зүйл, заалтын дугаар	Тэмдэг-лэгээ /-/ /+/	Нэмэлт өөрчлөлт оруулсан ажилтны нэр/гарын үсэг/	Хянасан албан тушаалтны нэр /гарын үсэг/
1		2026.09.25	“ИНҮТ” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/451 дүгээр тушаал, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбоотойгоор шинэчлэв.			

ГАРЧИГ

Бүлэг	Агуулга	Хуудас
1 бүлэг	**Ерөнхий зүйл**	3
1.1	Зорилго	3
1.2	Үндэслэл	3
1.3	Товчилсон үгсийн тайлбар	3
1.4	Холбогдох байгууллагууд	3
2 бүлэг	**Харилцан ажиллагаа**	4-6
2.1	Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны хариуцах үйл ажиллагаа	4-5
2.2	Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын хариуцах үйл ажиллагаа	5-6
3 бүлэг	**Бусад**	6-7
3.1	Журмын хэрэгжилтэд хяналт тавих	6
3.2	Журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, дүгнэх	6
3.3	Журамд өөрчлөлт оруулах	6
3.4	Хариуцах ажилтнууд	7
3.5	Томилогдсон хариуцах ажилтнууд	7

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Зорилго

1.1.1 Энэхүү журмын зорилго нь Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба (цаашид НУТА гэх), “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал (цаашид “Буянт-Ухаа” ОУНБ гэх) хоорондын харилцан ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Үндэслэл

1.2.1 Энэхүү журам нь “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам” болон “Буянт-Ухаа” ОУНБ-ын “Ерөнхий заавар”-ын шаардлагуудыг үндэслэн боловсруулагдсан болно.

1.3 Товчилсон үгсийн тайлбар

1.3.1 Энэхүү журамд дараах товчилсон үгсийг ашиглана. Үүнд:

• ИНҮТ ТӨХХК	Иргэний нисэхийн үндэсний төв Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани
• AMHS	Нисэхийн суурин холбооны сүлжээ
• ОУНБ	Олон улсын нисэх буудал
• АГУХ	Аврах, гал унтраах хэсэг
• ЕЗ	Ерөнхий зохицуулагч
• НТБГ	Нислэгийн төлөвлөлт, бүртгэл, гүйцэтгэл
• НУТА	Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба
• НУТЦХХ	Нислэгийн урсгал төлөвлөлт цагийн хуваарийн хэсэг
• НШТХ	Нислэгийн шуурхай төлөвлөлтийн хэсэг
• ҮТХ	Үйлдвэрлэл, төлөвлөлтийн хэлтэс
• ААА	Аэродром ашиглалтын алба
• ЗСХ	Захиргаа, санхүүгийн хэлтэс
• CDM	Хамтын шийдвэр гаргалт

1.4 Холбогдох байгууллагууд

1.4.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба

Монгол Улсын агаарын зайд нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйлчилгээг үзүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх гадаад дотоодын агаарын тээвэрлэгчдийн нислэгийн хүсэлт, олон улсын өнгөрөлт, хөөрөлт буулт, орон нутгийн нислэгүүдийн холбогдох материалуудыг хүлээн авч, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах нэгж.

1.4.2 “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал

Аэродром, зорчигч үйлчилгээний барилга, байгууламж бүхий агаарын хөлөг, зорчигчдод үйлчилгээ үзүүлэх ИНД-139-өөр гэрчилгээжсэн байгууллага

2. ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

2.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны хариуцах үйл ажиллагаа

2.1.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, хамтын шийдвэр гаргалт (CDM)-ыг хэрэгжүүлэхэд “Буянт-Ухаа” ОУНБ-тай хамтран ажиллана.

2.1.2 НУТА нь урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээг өмнөх өдөрт “Буянт-Ухаа” ОУНБ-ын ерөнхий зохицуулагчид airport_operation@mcaa.gov.mn, цахим хаягаар хүргүүлнэ.

2.1.3 “Буянт-Ухаа” ОУНБ-ын ерөнхий зохицуулагчийн ажлын байранд байршуулсан ATFMS сүлжээний Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ цэсээр дамжуулан урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд орсон өөрчлөлтүүд (хойшилсон, цуцалсан, өөрчлөгдсөн, нэмэгдсэн)-ийн мэдээ, мэдээлэл болон шуурхай төлөвлөлтөөр нэмэгдэж байгаа хуваарьт бус нислэгийн мэдээллээр хангаж ажиллана.

2.1.4 ATFMS сүлжээнд доголдол үүссэн тохиолдолд нислэгийн урьдчилсан төлөвлөлтөд орсон өөрчлөлтүүд болон шуурхай төлөвлөлтөөр нэмэгдэж байгаа хуваарьт бус нислэгийн мэдээллийг “Буянт-Ухаа” ОУНБ-ын ерөнхий зохицуулагчид AMHS сүлжээгээр (AMHS татгалзсан тохиолдолд airport_operation@mcaa.gov..mn цахим хаягаар) тухай бүр дамжуулна.

2.1.5 “Буянт-Ухаа” ОУНБ-ын ЗСХ-ээс ирүүлсэн төлбөрийн хугацаа хэтэрсэн дотоод болон гадаадын агаарын тээвэрлэгчдийн мэдээллийг хүлээн авч хамтран ажиллана.

2.1.6 Нисэх буудлын хүчин чадал хэтэрсэн (цаг агаарын болон бусад шалтгааны улмаас төлөвлөгдсөн нислэгүүд саатах г.м) үед НУТА нь “Буянт-Ухаа” ОУНБ-тай Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ.

2.1.7 Хамтын шийдвэр гаргах үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг airport_operation@mcaa.gov.mn цахим хаяг 71-283047 дугаарын утсанд эсхүл албан бичгээр мэдээлнэ.

2.1.8 “Буянт-Ухаа” ОУНБ-аас хүсэлт гаргасан тохиолдолд үйлдэгдсэн нислэгийн гүйцэтгэлийн мэдээг ЗСХ-ийн fed.charter@airport.gov.mn эсхүл ерөнхий зохицуулагчийн airport_operation@mcaa.gov.mn цахим хаягаар хүргүүлнэ.

2.1.9 “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам”-д өөрчлөлт орсон тохиолдолд “Буянт-Ухаа” ОУНБ -д мэдэгдэнэ.

2.1.10 НУТА-аас гарч буй нислэгийн төлөвлөлтийн мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

2.1.11 Нисэх буудалд онцгой нөхцөл тохиолдсон үед нисэх буудлын Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний дагуу ажиллана.

2.2 “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын хариуцах үйл ажиллагаа

2.2.1 “Буянт-Ухаа” ОУНБ нь Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, хамтын шийдвэр гаргалт (CDM)-ыг хэрэгжүүлэхэд НУТА-тай хамтран ажиллана.

2.2.1 Нисэх буудлын хүчин чадал хэтэрсэн (цаг агаарын болон бусад шалтгааны улмаас төлөвлөгдсөн нислэгүүд саатах г.м) үед “Буянт-Ухаа” ОУНБ нь НУТА-тай Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ.

2.2.2 Нисэх буудлын ажиллах цагийн хуваариас бусад цагуудад шуурхай төлөвлөлтийн үе шатанд төлөвлөгдөх нэмэгдэл нислэгийн мэдээллийг ерөнхий зохицуулагч цахимаар (airport operation@mcaa.gov.mn) эсхүл утсаар (71283047) агаарын тээвэрлэгчээс хүлээн авмагц аэродром нээлттэй тухай NOTAM мэдээ зарлуулна.

2.2.3 НУТА-аас ирүүлсэн Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд орсон өөрчлөлтүүд (хойшилсон, цуцалсан, өөрчлөгдсөн, нэмэгдсэн)-ийн мэдээ, мэдээллийг хүлээн авсан нисэх буудлын Ерөнхий зохицуулагч нь нисэх буудлын холбогдох нэгжүүдийг мэдээллээр хангаж ажиллана.

2.2.4 “Буянт-Ухаа” ОУНБ-ын ЗСХ нь төлбөрийн хугацаа хэтэрсэн дотоод болон гадаадын агаарын тээвэрлэгчдийн мэдээллийг НУТА-нд хүргүүлж, мэдээлэл солилцон хамтран ажиллана.

2.2.5 Нисэх буудлын хүчин чадал хэтэрсэн үед “Буянт-Ухаа” ОУНБ нь НУТА-тай Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ.

2.2.6 “Буянт-Ухаа” ОУНБ-д онцгой нөхцөл тохиолдож, “Ерөнхий заавар”-ын 3 дугаар бүлэг “Онцгой нөхцөлийн төлөвлөгөө”-ний дагуу КОД зарлагдсан тохиолдолд Ерөнхий зохицуулагч (712283047) нь НУТА-нд (71-281602) утсаар мэдэгдэнэ.

2.2.7 Хамтын шийдвэр гаргах үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг fpd@mcaa.gov.mn, tpu@mcaa.gov.mn цахим хаяг, 71-282232, 71-281602 дугаарын утсанд эсхүл албан бичгээр мэдээлнэ.

2.2.8 “Ерөнхий заавар” болон энэхүү журамтай холбоотой бусад баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийн талаар НУТА-нд цаг тухайд нь албан бичгээр хүргүүлнэ.

2.2.9 Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглана.

2.2.10 Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд байршуулах, бусдад дамжуулахыг хориглоно.

3. БУСАД ЗҮЙЛ

3.1 Журмын үл тохирлыг илтгэх

3.1.1 Журамтай холбоотой үл тохирол илэрсэн тохиолдолд талууд албан бичгээр харилцан мэдэгдэнэ.

3.2 Журмын хэрэгжилтийг дүгнэх

3.2.1 Журмын хэрэгжилтэд талууд хяналт тавьж ажиллана.
3.2.2 Талууд энэхүү журмын хэрэгжилтийг жил бүр дүгнэнэ.
3.2.3 Хэрэгжилтийг дүгнэхэд гарсан саналын дагуу талууд холбогдох арга хэмжээг авч ажиллана.
3.2.4 Талууд энэхүү журмын заалтуудыг зөрчсөн аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэж байх ба авсан арга хэмжээний талаар үндсэн хариуцагчид мэдэгдэнэ.

3.3 Журамд өөрчлөлт оруулах

3.3.1 Энэхүү харилцан ажиллагааны зохицуулалтын журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг талууд тухай бүр гаргана.
3.3.2 Журамд оруулах саналыг талууд харилцан зөвшөөрсөн тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг оруулна.
3.3.3 Талууд журамд тусгагдсан утас, цахим шуудангийн хаягт өөрчлөлт орсон тохиолдолд үндсэн хариуцагчид мэдэгдэнэ.

3.4 Хариуцах ажилтнууд

Байгууллага	Үндсэн хариуцагч	Хоёрдогч хариуцагч
Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба	Т.Энхчимэг НУТЦХХ-ийн Дарга Утас: 71 283332 Ц/ш: enkhchimeg.t@ncac.mn	Г.Мөнгөлдэй Дарга Утас: 71 283330 Ц/ш: munguldei@ncac.mn
“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал	Б.Цэдэвдорж УТХ-ийн дарга Утас: 71283022 Ц/ш: tsedevdorj.b@ncac.mn	Л.Отгонжаргал Захирал Утас: 71-283001 Ц/ш: otgonjgrgal.l@ncac.mn

3.5 Томилогдсон хариуцах ажилтнууд

Мэдээлэл	Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба	"Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудал
Нислэгийн төлөвлөгөө, мэдээлэл дамжуулах нэгж, ажлын байр	НУТЦХХ-ийн нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн Утас-71 282235 71 282029 Ц/ш: fpd@mcaa.gov.mn НШТХ-ийн нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн Утас: 71-281602 Ц/ш: tpu@mcaa.gov.mn	Ерөнхий зохицуулагч Утас: 71-283047 Ц/ш: airport_operation@mcaa.gov.mn Үйлдвэрлэл, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэрлэлийн ахлах мэргэжилтэн Утас: 71-283079 Ц/ш: zoljargal.d@ncac.mn ЗСХ-ийн няггтлан бодогч Утас:71283057 Ц/ш: enkhjargal.s@ncac.mn